



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө төрийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.1.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Жайка Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хооронд байгуулсан “Grant agreement №1560020” гэрээний дагуу буцалтгүй тусламжаар баригдан ашиглалтад орсон 166,036,081,200.00 (нэг зуун жаран зургаан тэрбум гучин зургаан сая наян нэгэн мянга хоёр зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн захирал Н.Хүрэлбаатар, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал Р.Отгонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан үндсэн хөрөнгөд бүртгэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132081353



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны дүгээр сарын 8-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА МОНГОЛ-ЯПОНЫ
ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Д/д	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн барилга	166,036,081,200.00	БА-072/2020
НИЙТ ДҮН		166,036,081,200.00	
		(нэг зуун жаран зургаан тэрбум гучин зургаан сая наян нэгэн мянга хоёр зуу)	